



“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 06 өдөр

Дугаар ...01.....

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Женко тур бюро”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. “Женко тур бюро” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 15-ны өдрийн 09:30 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Шангри-Ла худалдааны төв, 4 давхарт, Өргөө-3 IMAX CINEMA, 4-р танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - b. 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
 - c. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - d. ТУЗ-ын үйл ажиллагааны зардлыг батлах тухай;
 - e. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
 - f. ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 16 дахь өдөр буюу 2020 оны 03 сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2020 оны 03 сарын 11-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 16 хоногийн дараа буюу 2020 оны 03 сарын 27-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис, өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани болон компанийн өөрийн байран дээрээс ирж танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.

Чингис Хааны өргөн чөлөө, Ш/Х-43, Баянгол Оффис 1 давхарт, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: 976-7012-0202 Факс: 976-11321705

И-Шуудан: info@genco-tour.mn www.genco-tour.mn

8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдрын өмнөх өдөр буюу 2020 оны 04 сарын 14-ний 15:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Д.Даянбилгүүн, хурал зохион байгуулах комиссийн даргаар Б.Батмөнх гишүүнээр Т.Отгонтамир, Б.Түмэн-Өлзий, Б.Түвшинбаяр, тооллогын комиссын даргаар О.Баярцэцэг, гишүүнээр Б.Эрдэнэдалай, Б.Тэмүүлэн, Л.Хүрэлсүх, О.Өнөрчимэг нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан журмын дагуу удирдан зохион байгуулах ажлыг гүйцэтгэх захирал /Ц.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Д.ДАЯНБИЛГҮҮН /